



## Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлж буй иргэдээс авсан 2024 оны 07 дугаар сарын сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл

**СУДАЛГААНЫ ЗОРИЛГО:** Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

**СЭТГЭЛ ХАНАМЖ:** Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

**АЧ ХОЛБОГДОЛ:** Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

**СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ:** Санал асуулгын түүвэр судалгааны аргыг ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

### СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ


- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

**МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ:** Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээний А заал 101 тоотоос иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.




## СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Зураг1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн хүйс:



**Дүгнэлт:** Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаанд 44 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 16 иргэн буюу 36.4% эмэгтэй, 28 иргэн буюу 63.6% нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.


График1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал:





**Дүгнэлт:** Судалгаанд оролцсон иргэдийн насны хувьд авч үзвэл 20-29 насны 7 иргэн буюу 15.9% , 30-39 насны 23 иргэн буюу 52,3% ,40-49 насны 9 иргэн буюу 20,5% , 50-59 насны 5 иргэн буюу 11,4% тус бүрийн тоон үзүүлэлтүүд гарсан байна.

**График2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээний төрөл**



**Дүгнэлт:** Судалгаанд оролцсон 44 иргэдийн тэтгэвэртэй холбоотой үйлчилгээг 8 иргэн буюу 18.2%, тэтгэмж 21 иргэн буюу 47.7%, сайн дурын даатгал 9 иргэн буюу 20.5%, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт 4 иргэн буюу 9.1%, зөвлөгөө мэдээлэл 2 иргэн буюу 4,5% тус бүр байна.


**Хүснэгт1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ шуурхай, хялбар:**

	Иргэдийн тоо	Хувь	
<b>Нийгмийн даатгалын байгууллага үйлчилгээ шуурхай, хялбар байсан уу?</b>	<b>Маш сайн</b>	<b>5</b>	<b>11.4%</b>
	<b>Сайн</b>	<b>36</b>	<b>81.8%</b>
	<b>Дунд</b>	<b>2</b>	<b>4.5%</b>
	<b>Муу</b>	<b>1</b>	<b>2.3%</b>
	<b>Маш муу</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт үр дүн</b>	<b>44</b>	<b>100%</b>	




**Дүгнэлт:** Судалгаанд оролцсон иргэдийн 5 даатгуулагч маш сайн үнэлгээг өгсөн ( 11.4% ), сайн үнэлгээг 36 даатгуулагч буюу ( 81.8% ), дунд үнэлгээг 2 даатгуулагч ( 4.5%), муу үнэлгээг 1 даатгуулагч буюу (2.3%), маш муу үнэлгээг өгөөгүй байна.

**Зураг2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээллээ бүрэн авсан байдал**



**Дүгнэлт:** Судалгаанд оролцсон иргэдийн “Тийм” гэсэн үнэлгээг 41 иргэн буюу (93.2%), “Үгүй” гэсэн үнэлгээг 3 иргэн буюу (6.8%) үнэлгээг өгсөн байна.

**Зураг 3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн зөвлөгөө, ажилтны харилцаа, хандлага үнэлгээ:**



**Дүгнэлт:** Судалгаанд оролцсон иргэдийн сэтгэл ханамжтай 41 иргэн буюу (93.2%) сэтгэл дундуур 3 иргэн (6.8%) тус бүр өгсөн байна.

**Зураг4:Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл ил тод байдал\Төлөвлөгөө, тайлан, хүний нөөц,худалдан авах ажиллагаа ..\**




**Дүгнэлт:** Судалгаанд оролцсон 44 иргэдийн “Тийм” үнэлгээг 1 иргэн буюу (2.3%), “Үгүй” үнэлгээг 41 иргэн буюу (93.2%), Мэдэхгүй үнэлгээг 2 иргэн буюу (4.5%) тус бүр үнэлсэн байна.

**График4: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн ойр дотны хамаатан садан, найз нөхөд ажилладаг бол түүгээр дамжуулан үйлчилгээ авсан уу?**



**Дүгнэлт:** Судалгаанд оролцсон 44 иргэдийн “Тийм” үнэлгээг 1 иргэн буюу 2.3%, “Үгүй” үнэлгээг 43 иргэн буюу 97.7% тус бүр үнэлсэн байна. Энэ нь иргэд эрх тэгш үйлчилгээг дэс дараалалттай авч байна.

**График5: Түүвэр судалгаанд оролцсон иргэд үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг өгөх, хандив туслалцаа үзүүлж байсан уу?**



**Дүгнэлт:** Судалгаанд оролцсон “Үгүй” үнэлгээг 44 иргэн буюу (100%) тус бүр үнэлсэн байна.

Судалгааны нэгтгэл хийсэн: ...../Н.Шүрэн-Эрдэнэ/